



ХАРХОРУМ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБА

ХАРХОРУМ ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ХАРХОРУМ ХОТ
ХАРХОРУМ ХОТ
ХАРХОРУМ ХОТ

ХАРХОРУМ ХОТ ХАРХОРУМ ХОТ
ХАРХОРУМ ХОТ

ХАРХОРУМ ХОТЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

НЭГ.ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

1.1.Түүхэн хэрэгцээ шаардлага

Орхоны хөндий нь эртний төрт улс болох Хүннү /МЭӨ 209-МЭ 93/ гүрний Луут хотоос эхлэн, Жужан /МЭ 330-555 он/-ны Мумо хот, Уйгур /МЭ745-840/-ын Хар балгас, Түрэгийн үеийн хаад, ноёдын тахилын онгон, Их Монгол улс /1220 он/-ын Хархорум хот зэрэг нийслэл хотоо байгуулж байсан манай улсын түүх, соёл, төрт ёсны голомт нутаг юм.

Эзэн Чингис хаан их ор суусны XV он, цагаан луу жил буюу 1220 онд Их Монгол Улсын нийслэл “Хархорум” хотыг байгуулах болсон талаар гэрэлт хөшөөнд тэмдэглэн үлдээжээ. Өгэдэй хаан Хархорум хотыг цогцлоон хөгжүүлэх үйл хэргийг үргэлжлүүлж, Гүюг, Мөнх хааны үед хотын суу алдар дэлхий даяар түгэн мандсан байна.

Хархорум хот нь “Энх тайвны бэлгэ тэмдэг” хот байсан бөгөөд Ислам, Христ, Будда зэрэг олон шашны урсгал нэг дор зэрэгцэн оршиж байсан бөгөөд эрдэмтэн мэргэд, уран бүтээлчид, гар урчууд, худалдаачид, хаад язгууртны элч төлөөлөгчид зорин ирдэг дэлхийн улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн төв байсныг түүхэн эх сурвалжуудад тэмдэглэн үлдээсэн.

1.2.Практик шаардлага

Бүс, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдлаас хот, суурин газрууд руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж Монгол улсын нийт газар нутгийн 0,3% эзэлдэг Нийслэл Улаанбаатар хотод хүн амын 50 хувь амьдарч, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 70 хувь, худалдаа үйлчилгээний 84 хувь, их, дээд сургуулийн 96 хувь төвлөрсөн. Үүнээс үүдэлтэй хүн амын хэт төвлөрөл, авто замын түгжрэл, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг асуудлууд жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

Иймд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын төвлөрлийг сааруулах, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс шинэ хотууд байгуулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Монгол Улсын Засгийн газраас Орхоны хөндийд Хархорум хотыг байгуулах зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Өгийнуур, Хашаат сумдын нутаг дэвсгэрт 189 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч хот байгуулахад шаардлагатай байр зүйн дэвсгэр зураг, ундны усны эх үүсвэрийн эрэл хайгуул, инженер геологи, археологи, палеонтологийн судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, Төлөвлөлтийн үзэл баримтлал зэргийг боловсруулж хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах нөхцөлийг бүрдүүлээд байна.

1.3.Хууль зүйн үндэслэл

1998 онд Улсын Их хурлаас ажлын хэсэг байгуулан Орхоны хөндийд Хархорум хотыг байгуулах судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд 2005 онд хот байгуулах газар сонгох судалгаа, 2006 онд хот байгуулах газарт өгсөн дүгнэлт зэрэг ажлууд хийгдсэн байна.

1.3.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 230 дугаар зарлиг:

Эзэн Чингис хааны Орхоны хөндийд Монголын эзэнт гүрний нийслэлийг байгуулж байсан түүхийн улбааг өртөөлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын төвлөрлийг сааруулах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах болон төрт ёсныхоо үнэт өвийг бэхжүүлэх, түүх соёлоо сэргээх үүднээс Хархорум хотыг сэргээн байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлийг Засгийн газарт өгч, ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн "Орхоны хөндийн соёлын дурсгалт газар"-ын өв, соёлыг хамгаалах, Монголын эзэнт гүрний эртний нийслэл Хархорум хотыг сэргээн байгуулах түүхэн үйл хэрэг, их бүтээн байгуулалтад манлайлан оролцохыг нийт ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад уриалсан болно.

1.3.2. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар тогтоол:

"Хот байгуулах тухай" тогтоолоор газрын байршил, хэмжээг тогтоож улсын тусгай хэрэгцээнд авах, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

1.3.3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоол:

"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Хархорум хотын бүтээн байгуулалтад шаардлагатай суурь судалгаа, иж бүрэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусган, дэд бүтэц, бүтээн байгуулалтын эхний ээлжийн ажлыг эхлүүлэхээр тусгагдсан.

1.3.4. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоол:

"Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-д Хархорум хотод үндэсний дата төвийн нөөц төв, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хотхон, 4Е ангиллын олон улсын нисэх буудал, бүсийн тээвэр, логиستيкийн төв, Улаанбаатар хот-Хархорум хот-Улиастай хот чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Улаанбаатар хот-Хархорум хот чиглэлийн авто зам, ачаа, зорчигч тээврийн төмөр зам барихаар тусгагдсан.

1.3.5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоол:

Хархорум хотыг Улсын зэрэглэлтэй хот байхаар тусгаж хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

1.3.6. Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль:

Хархорум хотыг сэргээн байгуулж, Монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

1.3.7. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 17 дугаар тогтоол:

Хархорум хотын эдэлбэр газрын хэмжээг 189,363.19 га-аар тогтоож, Хархорум хотын эдэлбэр газрын хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, байршлыг баталсан.

ХОЁР. ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАРЧИМ

Хархорум хотыг сэргээн байгуулж, Монгол үндэстний түүх, язгуур өв, нүүдлийн соёл иргэншлийг хамгаалах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, амьдрахад таатай орчин бүрдүүлсэн хотыг байгуулахдаа дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

2.1.Монгол үндэстэн, угсаатны уламжлалт үнэт зүйл, түүх, соёлын биет болон биет бус өвийг сэргээх, хадгалан хамгаалах;

2.2.Түүх, соёлын дурсгалт газар, археологи, соёлын биет болон биет бус өв, байгалийн онцлог, нүүдлийн соёл иргэншилд түшиглэн олон төрөлт, тогтвортой аялал жуулчлалыг дэмжих;

2.3.Бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан, эдийн засгийн хувьд Хангайн бүсийн хөгжлийг дэмжиж, бие даан хөгжих боломжтой байх;

2.4.Тогтвортой хөгжлийн зорилгыг хангах хөрөнгө оруулалтыг дэмжих;

2.5.Хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа оршин суугчийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн, нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, хүмүүнлэг, олон төвт хотын тогтолцоог хөгжүүлэх;

2.6.Дэвшилтэт технологи, инновацад суурилсан ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх;

2.7.Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих;

2.8.Сэргээгдэх эрчим хүчний олон төрлийг дэмжих;

2.9.Орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.10.Улаанбаатар хот болон бусад бүс нутагтай холбогдох зорчигч болон ачаа тээврийн сүлжээг хөгжүүлэх.

ГУРАВ. ХОТЫН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Газар нутгийн түүхэн онцлог, хот, суурин газрын өнөөгийн нөхцөл байдал, бүс нутгийн тэнцвэргүй хөгжил, хүн ам, нийгэм, эдийн засгийн өсөлт, байгаль, уур амьсгалын өөрчлөлт болон олон улсын хот төлөвлөлтийн орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн дараах хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Түүх, соёлын олон төрөлт аялал жуулчлалын хот
2. Хөдөө аж ахуйн кластер төв хот
3. Шинжлэх ухаан, өндөр технологийн үйлдвэрлэлийн хот
4. Олон улсын бизнес, хамтын ажиллагааг хөгжүүлсэн хот
5. Хангайн бүсийн тээвэр логистикийн төв хот

3.1. ТҮҮХ, СОЁЛЫН ОЛОН ТӨРӨЛТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОТ

Орхоны хөндийн түүх, соёлын дурсгалт газар, археологи, соёлын биет болон биет бус өв, байгалийн онцлог, нүүдлийн соёл иргэншилд түшиглэн олон төрөлт, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- 3.1.1 Түүхэн аялал жуулчлал:** Орхоны хөндийд орших эртний төрт улсуудын нийслэл хотуудын туурь, түүх, соёлын дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын коридорыг бий болгоно.
- 3.1.2 Археологи, палеонтологийн аялал жуулчлал:** Эртний нийслэл Хархорум хотын туурь болон бусад археологийн олдворыг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, соёлын олон төрөлт үйл ажиллагаа явуулж иргэд, олон нийтэд сурталчлан таниулна.
- 3.1.3 Үндэсний соёл, урлаг, спортыг сурталчилсан аялал жуулчлал:** Олон улсын соёл, урлаг, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулна.
- 3.1.4 Уламжлалт ахуйн соёлд суурилсан аялал жуулчлал:** Соёлын биет болон биет бус өвд тулгуурлан Монгол ахуй, ёс заншил, өв уламжлал, нүүдлийн соёл иргэншлийг сурталчлан таниулах цогцолбор төвийг байгуулна.
- 3.1.5 Уламжлалт анагаах ухаанд суурилсан эрүүл мэндийн аялал жуулчлал:** Рашаан сувилалд түшиглэсэн амралт, нөхөн сэргээх аялал жуулчлалын цогцолбор байгуулна.
- 3.1.6 Хөрш орнуудын бүс нутгийг хамарсан олон улсын аялал жуулчлал:** Хөрш улсуудын байгалийн үзэсгэлэнт газар болон Монгол орны говь, хангайг хосолсон аялал жуулчлалын шинэ коридорыг байгуулж зангилаа төв болон хөгжинө.
- 3.1.7 Хотын түүх, төлөвлөлттэй танилцах виртуал аялал жуулчлал:** Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг виртуал орчинд шилжүүлж эртний хотын туурь, түүхэн олдвор, XIII зууны үеийн Хархорум хотын өнгө төрх, ирээдүйн хотын хөгжлийн төсөөлөлтэй танилцах боломжийг бүрдүүлнэ.

Үр дүн: Жилд ирэх жуулчдын тоог нэмэгдүүлж, бүс нутгийн эдийн засаг хөгжих боломжийг бүрдүүлнэ. Аялал жуулчлал, нийгмийн дэд бүтэц, худалдаа үйлчилгээний салбарыг хөгжүүлснээр 98,747 ажлын байрыг бий болгон 227,000 хүн амын ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

3.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН КЛАСТЕР ТӨВ ХОТ

Орхоны хөндийн байгалийн нөхцөл, бүс нутгийн мал аж ахуйн нөөцөд тулгуурлан хөдөө аж ахуйн кластер төв байгуулна.

- 3.2.1 Органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:** Химийн нэмэлтгүй эрүүл хүнсний /мах, сүү, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо/ бүтээгдэхүүний үйлдвэрлэл байгуулна.
- 3.2.2 Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл /фермер/:** Малын гаралтай бүтээгдэхүүний /мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн/ үйлдвэрлэл байгуулна.
- 3.2.3 Эмийн ургамлын тариалалт, байгалийн гаралтай эмийн үйлдвэрлэл:** Орхоны хөндийн байгалийн нөхцөл, уламжлалт анагаах ухааны мэдлэг, дэлхийн зах зээл дэх байгалийн гаралтай эмийн эрэлтэд тулгуурлан

эмийн ургамлыг боловсруулж, байгалийн гаралтай эм, нэмэлт тэжээл үйлдвэрлэж нэмүү өртөг шингээсэн экспортыг хөгжүүлнэ.

3.2.4 Цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлэх арьс шир, ноос, ноолууран бүтээгдэхүүний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл: Бүс нутгийн мал аж ахуйн нөөцөд тулгуурлан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээг ханган, улмаар экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.2.5 Агропарк: Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, техник, технологийн бааз, төрөлжсөн агуулахын нэгдсэн цогцолборыг байгуулна.

Үр дүн: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүс нутгийн иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, ажлын байр, орлогыг нэмэгдүүлнэ. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлснээр 35,465 ажлын байрыг бий болгон 85,000 хүн амын ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

3.3. ШИНЖЛЭХ УХААН, ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХОТ

Хархорум хотын газар нутаг, уур амьсгалын онцлог давуу талд тулгуурлан Шинжлэх ухаан, технологийн туршилт, судалгаа явуулдаг технологийн судалгааны төв, бүс нутгийн мэдээллийн дата төв, шинжлэх ухааны парк, үйлдвэрлэл технологийн парк байгуулна.

3.3.1 Шинжлэх ухаан, технологийн парк: Мэдээллийн технологийн парк, шинжлэх ухаан, технологийн туршилт, судалгаа, хөгжүүлэлт үйлдвэрлэлийн төв байгуулна.

3.3.2 Өндөр технологийн үйлдвэрлэл: Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан биотехнологи, нано технологи, электроникийн үйлдвэрийг байгуулна.

3.3.3 Үндэсний болон олон улсын дата төв: Байгаль, цаг уур, байршлын давуу талаа ашиглаж дата төвийг байгуулж үндэсний болон олон улсын мэдээлэл технологийн компаниудтай хамтран ажиллана.

3.3.4 Ухаалаг технологи хөгжүүлэлтийн төв: Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийг хөгжүүлнэ.

3.3.5 Ухаалаг удирдлагын нэгдсэн төв: Хотын инженерийн дэд бүтэц, замын хөдөлгөөн, нийтийн тээвэр, орчны аюулгүй байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны стандартыг хэмжих, хянах, мэдээлэх нөхцөлийг бүрдүүлсэн дэвшилтэт технологид суурилсан ухаалаг удирдлагын нэгдсэн төв байгуулна.

Үр дүн: Хархорум хотыг орчин үеийн хөгжлийн загвараар хөгжүүлж жишиг ухаалаг хот болгоно. Мэдээлэл, харилцаа холбоо, шинжлэх ухаан, өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлснээр 30,528 ажлын байрыг бий болгож 75,700 хүн амын ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

3.4. ОЛОН УЛСЫН БИЗНЕС, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛСЭН ХОТ

Хархорум хот нь дэлхийн улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн төв байсан түүхэн уламжлалыг хадгалан гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын харилцааг дэмжсэн зангилаа төв болгон хөгжүүлнэ.

- 3.4.1 Олон улсын байгууллагуудын салбар:** Дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудын салбарыг байгуулна.
- 3.4.2 Дипломат төлөөлөгчийн салбар байгууллага:** Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газрыг байгуулна.
- 3.4.3 Чөлөөт бүс /өндөр технологи, эрүүл мэнд, аялал жуулчлал/:** Татварын хөнгөлөлттэй бүс байгуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татна.
- 3.4.4 Олон улсын хурал, чуулга уулзалт, үзэсгэлэн худалдааны цогцолбор:** Олон улсын хурал, чуулга уулзалт, үзэсгэлэн худалдаа, бизнесийн форум, уралдаан, тэмцээн зохион байгуулах төвүүдийг байгуулна.
- 3.4.5 Олон улсын бизнес, санхүүгийн байгууллагууд:** Олон улсын банк, санхүүгийн салбар, хөрөнгийн биржийг байгуулна.
- 3.4.6 Гадаад, дотоодын их дээд сургуулийн салбарууд:** Олон улс, бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн салбар сургууль, судалгааны төвийг байгуулна.

Үр дүн: Хотын бүтээн байгуулалтад олон улсын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулж, гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Олон улсын байгууллага, банк, санхүү, их дээд сургуулиудын үйл ажиллагааг хөгжүүлснээр 23,850 ажлын байрыг бий болгож 54,860 хүн ам ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

3.5. ХАНГАЙН БҮСИЙН ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ТӨВ ХОТ

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын хүрээнд хөндлөн болон босоо чиглэлийн дэд бүтцийн тэнхлэгийн зангилаа, Хангайн бүсийн тээвэр логистикийн төв хот болон хөгжинө.

- 3.5.1 Бүсийн тээвэр, логистикийн төв:** Улаанбаатар хот-Хархорум хот чиглэлийн төмөр зам, авто зам, олон улсын нисэх онгоцны буудалд тулгуурлан тээврийн терминал, агаарын карго, томоохон бөөний худалдааны төв, нэгдсэн агуулах байгуулна.
- 3.5.2 Олон улсын нисэх онгоцны буудал:** Олон улсын 4Е ангилалын нисэх онгоцны буудлыг байгуулан зорчигч тээврийн урсгал, дамжин өнгөрөх агаарын тээврийн тоог нэмэгдүүлж, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.
- 3.5.3 Хэвтээ болон босоо чиглэлийн дэд бүтцийн зангилаа төв:** Хэвтээ болон босоо чиглэлийн дараах дэд бүтцүүдийг байгуулна. Үүнд:
- Улаанбаатар хот-Лүн сум чиглэлийн авто замыг 6 эгнээ, Лүн сум-Хархорум хот чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчилнэ;
 - Улаанбаатар хот-Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн төмөр замыг байгуулна;
 - Улаанбаатар хот-Хархорум хот чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц байгуулна;
 - Улс, хот хоорондын өгөгдөл дамжуулах сүлжээг хянах, удирдах, бүсийн үндсэн сүлжээний зангилаа төв байгуулна;

- Бага-Илэнх боомт, Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын сүлжээнд холбогдоно.

Үр дүн: Бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийн ханган Улаанбаатар хот руу чиглэх шилжилт хөдөлгөөнийг бууруулж, хэт төвлөрлийг сааруулна. Бүс нутгийн тээвэр, логистикийн үйл ажиллагааг хөгжүүлснээр 24,300 ажлын байрыг бий болгон 56,386 хүн ам ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

3.6. Орон зайн үзэл баримтлал

- 3.6.1 Суурьшлын бүсийн бүтэц:** Хархорум хотын 189 мянган га эдэлбэр газар нь Өгий нуурыг түшиглэсэн аялал жуулчлалын бүс, Шинээр байгуулах олон улсын нисэх буудлыг дагасан тээвэр логистикийн бүс, эртний Хархорум хотын туурийг түшиглэсэн хотын үндсэн суурьшлын бүсүүдтэй байна. Суурьшлын бүсүүдийн хооронд нүүдлийн мал аж ахуйн бэлчээр, ан амьтны шилжих хөдөлгөөнийг хадгалан экологийн коридор байгуулна.
- 3.6.2 Орон зайн төлөвлөлт:** Хотын орон зайн бүтцийг Монгол уламжлалт ахуй, түүх, соёлын бэлгэдлийг шингээж, хот төлөвлөлтийн онол арга зүйн хувьд ирээдүйд тэлэх боломжтой радиал /тойрог, цацраг/ систем бүхий зорчигч тээврийн урсгалыг дэмжсэн түгжрэлгүй хотыг байгуулна. Хотын төв болон хорооллуудыг холбосон ойн зурвасыг байгуулна.
- 3.6.3 Хүн амын төлөвлөлт:** Оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор хотыг 500 мянган хүн амтай байхаар тооцож, барилгажилтын нягтралыг олон улсын жишигт нийцүүлэн төлөвлөсөн. Хот нь нийгэм, эдийн засгийн хувьд бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлж, тэргүүлэх чиглэлийн хүрээнд 213 мянган ажлыг байрыг бий болгон бүс нутгийн хөгжилд эерэг нөлөөллийг үзүүлнэ.
- 3.6.4 Олон төвт хүртээмжтэй хотын төлөвлөлт:** Иргэд оршин суугаа газраасаа 300-800 метр зайд нийгэм, соёлын болон эрүүл мэндийн үйлчилгээ авах, амрах, зугаалах, цэцэрлэгт хүрээлэн, худалдаа, үйлчилгээний газарт хүрэх боломжийг бүрдүүлсэн хүртээмжтэй хотыг байгуулна. Хотын эдэлбэр газрын хэмжээнд 3 бүс, үндсэн суурьшлын бүсийн хэмжээнд дэд төвүүд/хороолол/-д хувааж олон төвт хотын тогтолцоог бүрдүүлнэ.

Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалын дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.